

# НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сонгинохайрхан Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2025/535/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он	НТАГ-ын дэд дарга	Ч.Болд
	Утас: 7000-7734	Цахим хаяг: <a href="mailto:boldch@audit.gov.mn">boldch@audit.gov.mn</a>
	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга	Х.Түвшинбаяр
	Утас: 315558	Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a>
	Аудитын менежер	Я.Алтанцэцэг
Утас: 325093	Цахим хаяг: <a href="mailto:altantsetseguya@audit.gov.mn">altantsetseguya@audit.gov.mn</a>	
Захирал	Д.Эхбаяр	
Утас: 70006948	Цахим хаяг: <a href="mailto:ekhbayar@sgmd-audit.mn">ekhbayar@sgmd-audit.mn</a>	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТОРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын тээврийн Г. Корлуц, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

№ 025, 02, 25 № 01/131  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

СОНГИНОХАЙРХАН НЭГДСЭН  
ЭМНЭЛГИЙН ЗАХИРАЛ  
Ц ОЛОНБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сонгинохайрхан Нэгдсэн эмнэлгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйцээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант оны эцэст НДШ болон ХХОАТ-ын 2,969.0 сая төгрөг, эмийн 4,741.6 сая төгрөгийн өглөгтэй байгаа нь батлагдсан төсвийг хэтрүүлэх эрсдэлтэй байна.

**Аудитын гол асуудал**

Тайланд онд Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-аас буюу орон нутгийн төсвөөс тус эмнэлгийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 1,091.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилго, 16 зорилтын хүрээнд 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

**Хоёр .Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>9,777,880,673.92</b>	<b>12,213,355,540.50</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>54,557,974.05</b>	<b>926,554,084.87</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>54,557,974.05</b>	<b>923,167,484.87</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>54,557,974.05</b>	<b>923,167,484.87</b>
31211	Төрийн сангийн харилцах	54,557,974.05	923,167,484.87
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	-	3,386,600.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>5,992,025,796.83</b>	<b>7,502,868,250.68</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	5,975,844,542.00	7,496,785,623.85
33300	Татаас, санхүүжилтийн авлага	156,738.38	156,738.38
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>16,024,516.45</b>	<b>5,925,888.45</b>
3351	Байгууллагаас авах авлага	10,578,628.00	480,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	5,445,888.45	5,445,888.45
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>3,731,296,903.04</b>	<b>3,783,933,204.95</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>1,148,573,095.97</b>	<b>1,096,386,056.35</b>
35130	Эм боох материал	1,148,573,095.97	1,096,386,056.35
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>2,582,723,807.07</b>	<b>2,687,547,148.60</b>
35410	Бичиг хэргийн материал	60,121,444.65	43,765,242.30
35420	Аж ахуйн материал	91,939,993.46	147,468,778.49
35430	Сэлбэг хэрэгсэл	8,656,550.00	14,641,650.00
35440	Түлш, шатах тослох материал	2,395,000.00	774,990.00
35450	Барилгын засварын материал	15,814,388.00	26,702,305.00
35470	Бусад хангамжийн материал	2,403,796,430.96	2,454,194,182.81
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>110,703,936,280.08</b>	<b>106,333,740,894.60</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>110,703,936,280.08</b>	<b>106,333,740,894.60</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>110,483,303,780.08</b>	<b>106,076,779,894.60</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	93,056,889,339.58	93,056,889,339.58
39202	Хуримтлагдсан элэгдэл	(5,969,916,279.57)	(8,379,616,534.68)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	973,466,096.56	942,966,096.56
39204	Хуримтлагдсан элэгдэл	(369,818,994.95)	(526,196,649.63)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	28,469,497,061.72	30,065,560,574.87
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,885,863,151.47)	(11,013,681,276.09)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,277,649,637.96	3,423,819,822.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,078,895,565.21)	(1,505,607,114.43)
39217	Ном	10,295,635.46	12,645,635.46
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>220,632,500.00</b>	<b>256,961,000.00</b>
39301	Програм хангамж	8,966,000.00	47,486,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,501,000.00)	(7,692,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	217,167,500.00	217,167,500.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>120,481,816,954.00</b>	<b>118,547,096,435.10</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,924,093,876.33</b>	<b>8,351,557,482.03</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,924,093,876.33</b>	<b>8,351,557,482.03</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>2,924,093,876.33</b>	<b>8,351,557,482.03</b>

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	520,722,009.22	2,959,011,878.81
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,316,817,853.59	5,176,307,688.22
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>86,554,013.52</b>	<b>216,237,915.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	86,554,013.52	216,237,915.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>117,557,723,077.67</b>	<b>110,195,538,953.07</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>117,557,723,077.67</b>	<b>110,195,538,953.07</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,038,924,480.23	2,038,924,480.23
51101	Өмч:- төрийн	2,038,924,480.23	2,038,924,480.23
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>112,712,548,770.35</b>	<b>105,350,364,645.75</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	119,072,713,247.72	112,712,548,770.35
51220	Тайлант үеийн үр дүн	(6,360,164,477.37)	(7,362,184,124.60)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,806,249,827.09	2,806,249,827.09
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>120,481,816,954.00</b>	<b>118,547,096,435.10</b>

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>25,772,848,385.73</b>	<b>35,331,838,402.88</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,184,265,243.73</b>	<b>2,808,240,154.38</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,184,265,243.73</b>	<b>2,808,240,154.38</b>
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,184,265,243.73	2,808,240,154.38
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,366,516,188.27	1,511,985,912.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	98,242,589.95	336,463,170.43
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан- Үндсэн хөрөнгө	421,931,632.13	539,772,507.21
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан - Бараа материал	297,574,833.38	420,018,564.74
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>23,588,583,142.00</b>	<b>32,523,598,248.50</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>46,656,000.00</b>	<b>105,000,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	46,656,000.00	105,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>-</b>	<b>1,096,449,606.18</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	1,096,449,606.18
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>23,541,927,142.00</b>	<b>31,322,148,642.32</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	31,322,148,642.32
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	23,541,927,142.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>32,133,012,863.10</b>	<b>42,694,022,527.48</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>32,133,012,863.10</b>	<b>42,694,022,527.48</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>32,103,989,363.10</b>	<b>42,189,893,440.44</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>15,659,010,455.69</b>	<b>19,323,389,817.54</b>
210101	Үндсэн цалин	8,683,786,023.37	10,439,713,098.88
210102	Нэмэгдэл	5,036,998,415.24	6,411,592,475.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	587,859,404.58	733,617,000.00
210104	Урамшуулал	1,350,366,612.50	1,738,467,243.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>2,057,689,511.60</b>	<b>2,424,778,524.76</b>
210201	Тэтгэврийн даатгал	1,404,635,320.13	1,657,558,939.16
210202	Тэтгэмжийн даатгал	201,152,958.13	192,943,034.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	126,360,857.62	126,608,024.29
210204	Ажилгүйдлийн даатгал	29,085,546.99	87,827,727.37
210205	Эрүүл мэндийн даатгал	296,454,828.73	359,840,799.14
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>946,030,795.63</b>	<b>1,091,449,606.18</b>

210301	Гэрэл, цахилгаан	513,109,683.82	625,964,302.66
210302	Түлш, халаалт	192,509,815.41	132,784,638.23
210303	Цэвэр, бохир ус	240,411,296.40	332,700,665.29
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>556,126,509.00</b>	<b>715,520,809.90</b>
210401	Бичиг хэрэг	104,698,870.05	145,375,950.35
210402	Тээвэр, шатахуун	41,912,700.00	36,690,160.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,945,427.40	35,251,884.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	221,676,447.98	376,482,209.22
210408	Бараа материал асгалсны зардал	179,893,063.57	121,720,606.33
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>9,199,187,990.54</b>	<b>11,827,250,670.74</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,775,221,990.54	9,454,183,170.74
210502	Хоол, хүнс	2,423,966,000.00	2,373,067,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,366,483,031.05</b>	<b>97,103,132.95</b>
210604	Урсгал засвар	1,366,483,031.05	97,103,132.95
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>59,427,577.31</b>	<b>89,966,441.23</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,000,000.00	46,556,260.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,224,000.00	8,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	705,510.00	791,370.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	666,444.00	2,338,011.23
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	495,800.00	165,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	31,966,181.10	25,815,800.00
210807	Газрын төлбөр	6,196,020.00	6,300,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	173,622.21	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,260,033,492.28</b>	<b>6,620,434,437.14</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,654,980.00	187,470,724.45
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,381,000.00	107,376,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,240,997,512.28	6,325,586,912.69
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>29,023,500.00</b>	<b>504,129,087.04</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>29,023,500.00</b>	<b>504,129,087.04</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	18,000,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	186,641,645.18
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,023,500.00	317,487,441.86
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(6,360,164,477.37)</b>	<b>(7,362,184,124.60)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(6,360,164,477.37)</b>	<b>(7,362,184,124.60)</b>

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>24,075,058,476.28</b>	<b>32,854,533,752.83</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,637,255,876.28</b>	<b>1,851,876,586.18</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,637,255,876.28</b>	<b>1,851,876,586.18</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,634,460,374.33	1,851,876,586.18
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,528,138,188.27	1,511,985,912.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	106,322,186.06	339,890,674.18
120009	Бусад орлого	2,795,501.95	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>22,437,802,600.00</b>	<b>31,002,657,166.65</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>46,656,000.00</b>	<b>105,000,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	46,656,000.00	105,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>-</b>	<b>1,096,449,606.18</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	1,096,449,606.18
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>22,391,146,600.00</b>	<b>29,801,207,560.47</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	29,801,207,560.47
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	22,391,146,600.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>26,799,479,899.83</b>	<b>30,670,362,457.01</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>26,799,479,899.83</b>	<b>30,670,362,457.01</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>26,770,456,399.83</b>	<b>30,166,233,369.97</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>15,586,214,227.67</b>	<b>18,012,577,477.29</b>
210101	Үндсэн цалин	7,720,670,053.25	9,351,593,691.12
210102	Нэмэгдэл	5,764,778,735.84	6,561,019,641.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	587,059,506.94	616,238,073.15
210104	Урамшуулал	1,513,705,931.64	1,483,726,071.28
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,611,375,065.00</b>	<b>1,300,946,499.17</b>
210201	Тэтгэврийн даатгал	1,110,600,979.04	940,972,152.14
210202	Тэтгэмжийн даатгал	130,626,807.50	91,178,047.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	103,316,608.69	57,771,813.08
210204	Ажилгүйдлийн даатгал	23,853,342.04	41,487,525.06
210205	Эрүүл мэндийн даатгал	242,977,327.73	169,536,961.52
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>942,014,266.10</b>	<b>1,091,449,606.18</b>
210301	Гэрэл, цахилгаан	513,109,683.82	598,537,533.13
210302	Түлш, халаалт	204,541,210.80	132,784,638.23
210303	Цэвэр, бохир ус	224,363,371.48	360,127,434.82
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>255,356,305.60</b>	<b>339,236,000.00</b>
210401	Бичиг хэрэг	50,503,720.00	44,793,374.00
210402	Тээвэр, шатахуун	36,307,700.00	32,570,150.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,945,427.40	10,093,259.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	133,671,858.20	185,224,578.80
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,927,600.00	66,554,638.20
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>6,841,745,902.10</b>	<b>8,763,438,247.98</b>

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,752,546,221.10	6,326,675,878.98
210502	Хоол, хүнс	2,024,269,831.00	2,388,012,369.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	64,929,850.00	48,750,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,401,596,076.05</b>	<b>297,041,275.75</b>
<b>210601</b>	<b>Багаж, техник, хэрэгсэл</b>	<b>-</b>	<b>15,520,000.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	73,408,600.80
210604	Урсгал засвар	1,401,596,076.05	208,112,674.95
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>113,118,577.31</b>	<b>131,395,981.60</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,000,000.00	47,486,160.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,224,000.00	8,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	705,510.00	791,370.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	666,444.00	746,680.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	495,800.00	165,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	31,966,181.10	26,778,271.60
210807	Газрын төлбөр	6,196,020.00	6,300,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	173,622.21	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	53,691,000.00	41,128,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>19,035,980.00</b>	<b>230,148,282.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,654,980.00	134,249,332.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,381,000.00	95,898,950.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>29,023,500.00</b>	<b>504,129,087.04</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>29,023,500.00</b>	<b>504,129,087.04</b>
213204	Ажил олгогчоос олгохбусад тэтгэмж, урамшуулал	18,000,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	186,641,645.18
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,023,500.00	317,487,441.86
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(2,724,421,423.55)</b>	<b>2,184,171,295.82</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>500,600,975.00</b>	<b>1,312,175,185.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>500,600,975.00</b>	<b>1,312,175,185.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>500,600,975.00</b>	<b>1,312,175,185.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	500,600,975.00	1,312,175,185.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(500,600,975.00)</b>	<b>(1,312,175,185.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(3,225,022,398.55)</b>	<b>871,996,110.82</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>3,279,580,372.60</b>	<b>54,557,974.05</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>54,557,974.05</b>	<b>926,554,084.87</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,038,924,480.23	2,806,249,827.09	119,072,713,247.72	123,917,887,555.04
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,038,924,480.23	2,806,249,827.09	119,072,713,247.72	123,917,887,555.04
7	Тайлант үеийн үр дүн	-	-	(6,360,164,477.37)	(6,360,164,477.37)
8	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,038,924,480.23	2,806,249,827.09	112,712,548,770.35	117,557,723,077.67
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,038,924,480.23	2,806,249,827.09	112,712,548,770.35	117,557,723,077.67
16	Тайлант үеийн үр дүн	-	-	(7,362,184,124.60)	(7,362,184,124.60)
17	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,038,924,480.23	2,806,249,827.09	105,350,364,645.75	110,195,538,953.07

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		54,557,974.05		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>35,191,968,900.00</b>	<b>31,877,537,642.01</b>	<b>3,314,431,257.99</b>	<b>91.0</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>35,191,968,900.00</b>	<b>31,877,537,642.01</b>	<b>3,314,431,257.99</b>	<b>91.0</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>34,687,639,100.00</b>	<b>31,373,408,554.97</b>	<b>3,314,230,545.03</b>	<b>90.0</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>19,672,841,900.00</b>	<b>18,012,577,477.29</b>	<b>1,660,264,422.71</b>	<b>91.6</b>
210101	Үндсэн цалин	8,837,066,400.00	9,351,593,691.12	(514,527,291.12)	105.8
210102	Нэмэгдэл	8,960,908,400.00	6,561,019,641.74	2,399,888,758.26	73.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,040,257,900.00	616,238,073.15	424,019,826.85	59.2
210104	Урамшуулал	834,609,200.00	1,483,726,071.28	(649,116,871.28)	177.8
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>2,244,598,600.00</b>	<b>1,300,946,499.17</b>	<b>943,652,100.83</b>	<b>58.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	1,669,532,000.00	940,972,152.14	728,559,847.86	56.4
210202	Тэтгэмжийн даатгал	143,766,700.00	91,178,047.37	52,588,652.63	63.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	71,883,300.00	57,771,813.08	14,111,486.92	80.4
210204	Ажилгүйдлийн даатгал	71,883,300.00	41,487,525.06	30,395,774.94	57.7
210205	Эрүүл мэндийн даатгал	287,533,300.00	169,536,961.52	117,996,338.48	59.0
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,095,000,000.00</b>	<b>1,091,449,606.18</b>	<b>3,550,393.82</b>	<b>99.7</b>
210301	Гэрэл, цахилгаан	568,000,000.00	598,537,533.13	(30,537,533.13)	105.4
210302	Түлш, халаалт	177,000,000.00	132,784,638.23	44,215,361.77	75.0
210303	Цэвэр, бохир ус	350,000,000.00	360,127,434.82	(10,127,434.82)	102.9
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>339,711,000.00</b>	<b>339,236,000.00</b>	<b>475,000.00</b>	<b>99.9</b>
210401	Бичиг хэрэг	44,559,200.00	44,793,374.00	(234,174.00)	100.5
210402	Тээвэр, шатахуун	43,058,600.00	32,570,150.00	10,488,450.00	75.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	43,333,000.00	10,093,259.00	33,239,741.00	23.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	173,760,200.00	185,224,578.80	(11,464,378.80)	106.6

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	35,000,000.00	66,554,638.20	(31,554,638.20)	190.2
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>9,132,561,000.00</b>	<b>8,766,738,247.98</b>	<b>365,822,752.02</b>	<b>96.0</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,295,262,100.00	6,329,975,878.98	965,286,221.02	86.8
210502	Хоол, хүнс	1,788,548,900.00	2,388,012,369.00	(599,463,469.00)	133.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	48,750,000.00	48,750,000.00	-	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,816,220,300.00</b>	<b>1,486,071,460.75</b>	<b>330,148,839.25</b>	<b>81.8</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,536,394,300.00	1,173,592,185.00	362,802,115.00	76.3
210602	Тавилга	84,300,000.00	86,958,000.00	(2,658,000.00)	103.2
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	50,000,000.00	73,408,600.80	(23,408,600.80)	146.8
210604	Урсгал засвар	145,526,000.00	152,112,674.95	(6,586,674.95)	104.5
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>150,713,000.00</b>	<b>140,395,981.60</b>	<b>10,317,018.40</b>	<b>93.2</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,714,600.00	47,486,160.00	2,228,440.00	95.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,000,000.00	8,000,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,490,000.00	791,370.00	698,630.00	53.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,490,000.00	746,680.00	743,320.00	50.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	600,000.00	165,000.00	435,000.00	27.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	40,900,900.00	35,778,271.60	5,122,628.40	87.5
210807	Газрын төлбөр	6,300,000.00	6,300,000.00	-	100.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,089,000.00	-	1,089,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	41,128,500.00	41,128,500.00	-	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>235,993,300.00</b>	<b>235,993,282.00</b>	<b>18.00</b>	<b>100.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	209,860,800.00	140,094,332.00	69,766,468.00	66.8

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,132,500.00	95,898,950.00	(69,766,450.00)	367.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>504,329,800.00</b>	<b>504,129,087.04</b>	<b>200,712.96</b>	<b>100.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>504,329,800.00</b>	<b>504,129,087.04</b>	<b>200,712.96</b>	<b>100.0</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	186,710,400.00	186,641,645.18	68,754.82	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	317,619,400.00	317,487,441.86	131,958.14	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>35,191,968,900.00</b>	<b>32,749,533,752.83</b>	<b>2,337,435,147.17</b>	<b>93.4</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,100,000,000.00</b>	<b>1,096,449,606.18</b>	<b>3,550,393.82</b>	<b>99.7</b>
132001	Орон нутгийн төсвөөс	1,100,000,000.00	1,096,449,606.18	3,550,393.82	99.7
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>32,122,145,900.00</b>	<b>29,801,207,560.47</b>	<b>2,320,938,339.53</b>	<b>92.8</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	32,122,145,900.00	29,801,207,560.47	2,320,938,339.53	92.8
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,969,823,000.00</b>	<b>1,851,876,586.18</b>	<b>12,946,413.82</b>	<b>99.3</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,509,526,700.00	1,511,985,912.00	(2,459,212.00)	100.2
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	405,738,300.00	339,890,674.18	65,847,625.82	83.8
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	54,558,000.00	-	54,558,000.00	-
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	<b>54,557,974.05</b>	<b>(54,557,974.05)</b>	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	<b>926,554,084.87</b>	<b>(926,554,084.87)</b>	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>659</b>	<b>624</b>	<b>35</b>	<b>94.7</b>
620001	Удирдах ажилтан	3	3	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	552	510	42	92.4
620003	Үйлчлэх ажилтан	104	87	17	83.7
620004	Гэрээт ажилтан	-	24	(24)	

## **Гурав. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 195,228.7 мянган төгрөгийн 3 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Ажиллагчидтай холбогдсон авлагыг хасах үлдэгдэлтэй илэрхийлэгдсэнээс Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн гүйлгээ балансын дүнгээс 4,070.6 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Ажилчдын цалингаас суутгаж төлсөн шүүхийн шийдвэрийн суутгалыг давхардуулан цалингийн зардалд бичиж цалингийн зардлыг нэмэгдүүлсэн;
- Тайлант оны нийт ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 161,043.5 мянган төгрөгөөр бууруулж тайлагнасан.

Аудитаар нийт 2,973,811.7 мянган төгрөгийн 12 зөрчил<sup>2</sup> илэрснээс, алдаа, зөрчлийг арилгах 313,752.8 мянган төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 2,660,058.9 мянган төгрөгийн зөрчилд 8 зөвлөмж өгсөн.

### **1. Албан шаардлага**

1.Тус эмнэлгээр үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн эмчийн үзлэг, шинжилгээний хариуг олгодог гэрэгэ киоск машины төлбөр тооцооны талаар тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй, гарсан ашиглалтын зардлын тооцооллыг хийж төлүүлээгүй, түрээсийн төлбөрийн гэрээ байгуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Харилцагч байгууллагаас авах орлогын болон ашиглалтын зардлын төлбөрийн тооцооллыг хийж актаар баталгаажуулаагүй, түрээсийн төлбөрийн гэрээ байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

2. Тайлант онд зөвлөх үйлчилгээний тендерийн гэрээт ажлын төлбөр 59,988.0 мянган төгрөгийг бүрэн шилжүүлсэн боловч гэрээ дүгнэсэн акт болон ажлын эцсийн тайлан байхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Гэрээ дүгнэсэн акт болон ажлын эцсийн тайлан бэлтгээгүй зөрчлийг зогсоож, дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

3. Өмнөх онуудад үүссэн 5,445.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Авлагын үлдэгдлийг барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, зөрчлийг зогсоож, дахин давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

4. Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерт шалгарсан Мөнхийн тун ХХК-нь тендерийн нээлтийн тэмдэглэлээр 275,911.0 мянган төгрөгийн үнийн санал ирүүлсэн, шалгарсан тухай албан мэдэгдэлд 248,319.0 мянган төгрөгийн үнийн саналаар гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн байна.

Үнэлгээний хороо нь Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалаар батлагдсан маягтуудын дагуу тендерийг үнэлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.10-т “Үнэлгээний хорооны дарга үнэлгээний хорооны үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, хурлыг товлох, тогтоосон хугацаанд шуурхай шийдвэр гаргаж, захиалагчид хүргүүлэх, үнэлгээний хороог захиалагчийн өмнө төлөөлөх чиг үүргийг хэрэгжүүлнэ.”, Сангийн сайдын 2023 оны 255 дугаар тушаалаар баталсан “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-тай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

## **2 Зөвлөмж**

### **1. Төсвийн гүйцэтгэлийн тайлагналтай холбоотой асуудал:**

Илрүүлэлт: Төсвийн гүйцэтгэлийн тайланг хуульд заасан бүрэлдэхүүний дагуу гаргаагүй нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1-д "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна", 54.5.1-д "тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/", 54.5.2-т "татварын зарлагыг хуулийн этгээд, салбар бүрээр, холбогдох эрх зүйн үндэслэлийн хамт;", 54.5.3-д "тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл;", 54.5.4-т "хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/", 54.5.5-т "нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан бүрэлдэхүүний дагуу гаргаж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

### **2. Бараа материалын дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал:**

Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн эм, эмнэлгийн хэрэгслийн эцсийн үлдэгдэл нь, эмч нарын өвчтөний түүх болон хэрэглэсэн эм, эмнэлгийн хэрэгслийн тоо ширхэгийг бүртгэдэг эмнэлгийн E-Health програмын эмийн үлдэгдэлтэй таарахгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах; 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа болон эмнэлгийн E-Health ашиглаж байгаа програмуудыг үлдэгдлийг тааруулж зөв болгох, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

### **3. Ажилчдын цалин хөлсний олголттой холбоотой асуудал:**

Илрүүлэлт: Ажлаас чөлөөлж байгаа ажилчдад ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо бодоогүй 1,594.0 мянган төгрөгийг дутуу тооцсон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 110.3-т "Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалинг олгоно" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажилчдад ажилласан хугацааны цалинг хуулийн дагуу бодож олгож байх, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

#### **4. Дотоод хяналттай холбоотой асуудал:**

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангаар тайлагнасан цалингаас санхүүгийн тайлангийн цалингийн зардалд тусгасан дүн нь 7,352.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах; 20.2.4 -т "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгсөн.

#### **5. Худалдан авалттай холбоотой асуудал;**

Илрүүлэлт: Захиалагч нь "Мэдээлэл технологийн үйлчилгээ" авах 52,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий ажил үйлчилгээний тендерийг зарлахдаа бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичгийг ашиглан тендер зарласан нь тендер шалгаруулалтын агуулга бүхэлдээ алдаатай, захиалагч нь буруу жишиг баримт бичгийн дагуу баталсан нь захиалагчаас шалтгаалан тендер амжилтгүй болох эрсдэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерийн жишиг баримт бичгийг зөв сонгон хэрэглэх, зөрчлийн давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

#### **6. Худалдан авалттай холбоотой асуудал;**

Илрүүлэлт: Худалдан авалтын баримт бичгийг холбогдох хууль, журмын дагуу архивын нэгж болгоогүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4-т "Захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулах бүрд тендер шалгаруулалтын хувийн хэрэг бүрдүүлж, түүнд дараах баримт бичгийг хавсаргана:", 48.4.1-д "санхүүжилтийн эх үүсвэр баталсан шийдвэр;", 48.4.2-т "нээлттэй тендер шалгаруулалтын аргаас өөр арга хэрэглэсэн тохиолдолд тухайн аргыг сонгох болсон үндэслэл;", 48.4.3-д "захиалагчийн баталсан тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;", 48.4.4 -т "захиалагч, оролцогчтой харилцсан албан бичиг;", 48.4.5-д "оролцогчдын ирүүлсэн тендер;", 48.4.6-д "үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, зөвлөмж", 48.4.7-д "тендер шалгаруулалт амжилтгүй болсон, эсхүл бүх тендерээс татгалзсан тохиолдолд түүний шалтгаан, үндэслэл", 48.4.8-д "захиалагчийн шийдвэр", 48.4.9-д "худалдан авах гэрээ", 48.4.10-т "энэ хуулийн 13.4-т зааснаар баримтжуулсан гэрэл зураг, дүрс бичлэг", 48.4.11-т "бусад баримт бичиг" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалттай холбоотой баримт бичгийг хуулийн дагуу архивын нэгж үүсгэж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

#### **7. Эмнэлгийн тусламж үйлчилгээний орлогын хасагдалтай холбоотой асуудал;**

Илрүүлэлт: Тайлант оны ЭМДСангаас нэхэмжилсэн тусламж үйлчилгээний орлого нийт 2,599,112.6 мянган төгрөгөөр хасагдал үүссэн байна. Тус хасагдлыг нягтлан бодох бүртгэлд тусгахгүй байгаа нь тайлант үеийн орлогыг бууруулж байна. Нийт хасагдлыг хянахад үзвэл байцаагчийн хасагдал 157,016.5 мянган төгрөг, цахим хяналтын хасагдал 1,186,002.8 мянган төгрөг, эмчийн 1,197,549.1 мянган төгрөг, эх олонлогийн түүврийн хасагдал 58,544.2 мянган төгрөг байна. Нийт хасагдал нь нэхэмжилсэн орлогын 8.08 %-ийг эзлэж байгаа нь байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах, өр төлбөр үүсэх эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх," гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хуулийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

#### **8. Мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой асуудал;**

Илрүүлэлт: Мэдээллийн аюулгүй байдлыг иж бүрэн хангаж, /холбогдох хуулийг/ хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тус эмнэлгийн мэдээллийг дамжуулж байгаа санхүүгийн болон хүний нөөцийн ажиллагсад албаны цахим хаяг ашиглахгүй байна. Улмаар мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажиллаж байгаа тодорхой бус байна.

Энэ нь Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Кибер орчинд дундын мэдээллийн системээр дамжуулан мэдээлэл боловсруулах, хадгалах, түгээх, цахим тооцооллын болон түүний хэвийн үйл ажиллагааг хангахад мэдээллийн технологийн чиглэлээр үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээд дараах үүргийг хүлээнэ", 17.1.1-д "кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журам батлах;", 17.1.3-д "мэдээллийн системийн үйлдлийн бүртгэлийг кибер аюулгүй байдлын нийтлэг журамд заасан хугацаанд хадгалах;", 17.1.4-т "кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны талаар холбогдох төрийн байгууллагаас мэргэжил, арга зүйн туслалцаа авч, хамтран ажиллах", 17.1.5-д "кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа хариуцсан нэгж, эсхүл албан тушаалтантай байх", 17.1.6-д "кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хоёр жил тутамд, холбогдох журамд заасан нөхцөл, байдал үүссэн үед тухай бүр хийлгэж, гарсан дүгнэлт, зөвлөмж, шаардлагын дагуу арга хэмжээг авч хэрэгжүүлэх", 19 дүгээр зүйлийн 19.1-д "Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагад дараах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага хамаарна", 19.1.3-т "хоёр, гуравдугаар шатлалын эрүүл мэндийн байгууллага;" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын үйл ажиллагаанд албан цахим хаяг ашиглах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажиллагчидтай холбогдсон авлагыг хасах үлдэгдэлтэй илэрхийлэгдсэнээс Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн гүйлгээ балансын дүнгээс 4,070.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	4.1	1	4.1	-	-	1	4.1	-	-	-	-
Ажилчдын цалингаас суутгаж төлсөн шүүхийн шийдвэрийн суутгалыг давхардуулан цалингийн зардалд бичиж цалингийн зардлаа нэмэгдүүлсэн.	1	30.1	-	-	1	30.1	1	30.1	-	-	-	-
Тайлант оны нийт ажил олгогчын нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 161,043.5 мянган төгрөгөөр бууруулж тайлагнасан байна.	1	161.0	-	-	1	161.0	1	161.0	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>195.2</b>	<b>1</b>	<b>4.1</b>	<b>2</b>	<b>191.2</b>	<b>3</b>	<b>195.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 заасан бүрэлдэхүүний дагуу гаргаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Санхүүгийн тайлангийн эм, эмнэлгийн хэрэгслийн эцсийн үлдэгдэл нь, эмч нарын өвчтөний түүх болон хэрэглэсэн эм, эмнэлгийн хэрэгслийн тоо ширхэгийг бүртгэдэг эмнэлгийн E-Health програмын эмийн үлдэгдэлтэй таарахгүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Ажлаас чөлөөлж байгаа ажилчдад ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо бодоогүй 1,594.0 мянган төгрөгийг дутуу тооцсон байна.	1	1.6	-	-	-	-	1	1.6	-	-	-	-
Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангаар тайлагнасан цалингаас санхүүгийн тайлангийн цалингийн зардалд тусгасан дүн нь 7,352.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	7.4	-	-	-	-	1	7.4	-	-	-	-
Тайлант онд зөвлөх үйлчилгээний тендерийн гэрээт ажлын төлбөр 59,988.0 мянган төгрөгийг бүрэн шилжүүлсэн, гэрээ дүгнэсэн акт болон ажлын эцсийн тайлан байхгүй байна.	1	60.0	-	-	1	60.0	-	-	-	-	-	-
Өмнөх онуудад үүссэн 5,445.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	5.4	-	-	1	5.4	-	-	-	-	-	-
Тус эмнэлгээр үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн эмчийн үзлэг, шинжилгээний хариуг олгодог гэрэгэ киоск машины гүйлгээний 11, 12 саруудын төлбөр төлөгдөөгүй, төлбөр тооцооны талаар тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй, гарсан ашиглалтын зардлын тооцооллыг хийж төлүүлээгүй, түрээсийн төлбөрийн гэрээ байгуулаагүй байна.	1	0.0	-	-	1	0.0	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>74.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>65.4</b>	<b>4</b>	<b>9.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Тайлант оны ЭМДСангаас нэхэмжилсэн тусламж үйлчилгээний орлого нийт 2,599,112.6 мянган төгрөгөөр хасагдал үүссэн байна. Тус хасагдлыг нягтлан бодох бүртгэлд тусгахгүй байгаа нь тайлант үеийн орлогыг бууруулж байна. Нийт хасагдлыг задлаж үзвэл байцаагчийн хасагдал 157,016.5 мянган төгрөг, цахим хяналтын хасагдал 1,186,002.8 мянган төгрөг, байцаагчийн хасагдал 1,197,549.1 мянган төгрөг, эх олонлогийн түүврийн хасагдал 58,544.2 мянган төгрөг байна. Нийт хасагдал нь нэхэмжилсэн орлогын 8.08 %-ийг эзлэж байгаа нь байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах, өр төлбөр үүсэх эрсдэлтэй байна.	1	2,599.1	-	-	-	-	1	2,599.1
Мэдээллийн аюулгүй байдлыг иж бүрэн хангаж, /холбогдох хуулийг/ хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тус эмнэлгийн мэдээллийг дамжуулж байгаа санхүүгийн болон хүний нөөцийн ажиллагсад албаны цахим хаяг ашиглахгүй байна. Улмаар мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажиллаж байгаа тодорхой бус байна.	1	-	-	-	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>2,599.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>2,599.1</b>
<b>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуультай холбоотой зөрчил</b>								
Худалдан авалтын баримт бичгийг холбогдох хууль, журмын дагуу архивын нэгж болгоогүй.	1	-	-	-	-	-	1	-
Захиалагч нь “Мэдээлэл технологийн үйлчилгээ” авах 52,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий үйлчилгээний тендерийг зарлахдаа бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичгийг ашиглан тендер зарласан нь тендер шалгаруулалтын агуулга бүхэлдээ алдаатай, захиалагч нь буруу жишиг баримт бичгийн дагуу баталсан байх нь захиалагчаас шалтгаалан тендер амжилтгүй болох эрсдэлтэй байна.	1	52.0	-	-	-	-	1	52.0
Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерт шалгарсан Мөнхийн тун ХХК-нь тендерийн нээлтийн тэмдэглэлээр 275,911.0 мянган төгрөгийн үнийн санал ирүүлсэн, шалгарсан тухай албан мэдэгдэлд 248,319.0 мянган төгрөгийн үнийн саналаар гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн. Үнэлгээний хороо нь Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалаар батлагдсан маягтуудын дагуу тендерийг үнэлээгүй байна.	1	248.3	-	-	1	248.3	-	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>300.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>248.3</b>	<b>2</b>	<b>52.3</b>
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>2,899.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>248.3</b>	<b>4</b>	<b>2,651.1</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			